



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 10

Зуунмод

Сум хөгжүүлэх сангийн 2021 оны
төсөв батлах тухай

Сумын сум хөгжүүлэх сангийн 2021 оны төсөв боловсруулсан тухай сумын Засаг дарга Ч.Сарангэрэлийн мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг төсөв санхүүгийн хорооноос гаргасан дүгнэлтийг хэлэлцээд, “Төсвийн тухай хууль”-ийн 64 дүгээр зүйлийн 64.1,2 дахь заалт, Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “б” дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Сум хөгжүүлэх сангийн 2021 оны төсөвт төвлөрүүлэх эргэн төлөгдөх зээлийн орлогын хэмжээг 250.000,0 мянган төгрөгөөр, зээлийн хүүгийн болон алдангийн орлогын хэмжээг 30.000,0 мянган төгрөгөөр, 2021 онд сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгох нийт зээлийн дээд хэмжээг 250.000,0 мянган төгрөг, нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 30.000,0 мянган төгрөг, сангийн үйл ажиллагааны зарлагын дээд хэмжээг 262.478,0 мянган төгрөгөөр тогтоож Нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Сум хөгжүүлэх сангийн 2021 оны төсвийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга /Ч.Сарангэрэл/-д үүрэг болгосугай.

2.1. Сум Хөгжүүлэх Сангийн 2021 оны батлагдсан төсөв, төсөл авах хугацаа, шалгаруулах явц, дэмжигдсэн төслийн талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл, телевиз, цахим орчинд мэдээллэж иргэдийн мэдэх эрхийг хангаж ажиллах.

2.2. Сангийн хүүгийн орлогыг бүрдүүлэхэд анхаарч дотоод хяналтыг сайжруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж буй байдалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийн, төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг төвлөрүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулж ажлыг шуурхай авч хэрэгжүүлэхийг тус тус үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА

Г.МӨНХБАДРАЛ

00000029

Зуунмод сумын ИТХ-ын Ес дэх удаагийн
сонгуулийн 2020 оны 12 сарын 17-ны өдрийн
II хуралдааны 10 тоот тогтоолын хавсралт



СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2021 ОНЫ ТӨСӨВ

		2020 оны батлагдсан төсөв		2021 оны төсөв	
№	Зардлын зүйл	Сард зарцуулах дүн /мян.төг/	Жилд зарцуулах дүн /мян.төг/	Сард зарцуулах дүн /мян.төг/	Жилд зарцуулах дүн /мян.төг/
1	Үндсэн цалин	732,6	8.791,2	732,6	8.791,2
2	НДШ	98,9	1.186,8	98,9	1.186,8
3	Бичиг хэрэг	30,0	360,0	30,0	360,0
4	Шатахуун	30,0	360,0	30,0	360,0
5	Шуудан холбоо	10,0	120,0	10	120,0
6	Сургалт сурталчилгаа	75,0	900,0	100,0	1.200,0
7	Зээл олголт		300.000,0		250.000,0
8	Үндсэн хөрөнгийн зардал		2.400,0		460,0
НИЙТ ДҮН		976,5	314.118,0	1.001,5	262.478,0

**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХОЁРДУГААР ХУРАЛДААН**